



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 115

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Багануур дүүрэгт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний барилгажилтын төслийн эхний ээлжийн барилга байгууламжийн дулаан дамжуулах төвийн ажлын хүрээнд бий болсон 32 нэрийн, нийт 4,593,739,727.00 (дөрвөн тэрбум таван зуун ерэн гурван сая долоон зуун гучин есөн мянга долоон зуун хорин долоо) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Багануурын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Багануурын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Ариун-Эрдэнэд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132061287
9-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн
116 дугаар тогтоолын хавсралт

"БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Бүртгэх дүн (төгрөг)
1	Халаалтын ялтас	2023	2	ш	30,000,000.00	60,000,000.00
2	Хэрэгцээний халуун ялтас 2300 Квт	2023	1	ш	30,000,000.00	30,000,000.00
3	Халаалтын насос	2023	3	ш	20,000,000.00	60,000,000.00
4	Хэрэгцээний халуун усны насос 22	2023	2	ш	20,000,000.00	40,000,000.00
5	Нэмэлт усны насос 50 м3/цаг	2023	2	ш	20,000,000.00	40,000,000.00
6	Даралт тохируулах хаалт ф150	2023	1	ш	15,000,000.00	15,000,000.00
7	Тэлэлтийн сав 2000 л	2023	2	ш	15,000,000.00	30,000,000.00
8	ХХУ-ын температур тохируулах хаалт	2023	2	ш	15,000,000.00	30,000,000.00
9	Халаалт температур тохируулах хаалт ф100	2023	2	ш	15,000,000.00	30,000,000.00
10	Ус зөөлрүүлэх бүрэн төхөөрөмж	2023	1	ком	20,000,000.00	20,000,000.00
11	Дулааны тоолуур 280 м3/цаг	2023	1	ш	25,000,000.00	25,000,000.00
12	Дулааны нэмэлт усны тоолуур 70 м3/цаг	2023	1	ш	15,000,000.00	15,000,000.00
13	Бөмбөлгөн хаалт ф200	2023	2	ш	5,000,000.00	10,000,000.00
14	Бөмбөлгөн хаалт ф150	2023	6	ш	2,500,000.00	15,000,000.00
15	Бөмбөлгөн хаалт ф250	2023	2	ш	6,000,000.00	12,000,000.00

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Бүртгэх дүн (төгрөг)
16	Бөмбөлгөн хаалт ф100	2023	7	ш	2,000,000.00	14,000,000.00
17	ХХУ-ын давтамж хувиргагч	2023	1	ш	25,000,000.00	25,000,000.00
18	Халаалтын давтамж хувиргагч	2023	1	ш	12,000,000.00	12,000,000.00
19	Нэмэлт усны давтамж хувиргагч	2023	1	ш	12,000,000.00	12,000,000.00
20	Цэвэр усны тоолуур ф100	2023	1	ш	5,000,000.00	5,000,000.00
21	Хог шүүгч ф200	2023	1	ш	3,000,000.00	3,000,000.00
22	Хог шүүгч ф150	2023	1	ш	2,500,000.00	2,500,000.00
23	Хог шүүгч ф100	2023	1	ш	2,000,000.00	2,000,000.00
24	Хог шүүгч ф80	2023	1	ш	998,769.00	998,769.00
25	Дулааны ф300 мм-ийн голчтой шугам	2023	4460	м	350,000.00	1,561,000,000.00
26	Силфон компенсатор Ф300	2023	4	ш	14,000,000.00	56,000,000.00
27	Дулааны худаг	2023	9	ком	15,000,000.00	135,000,000.00
28	Ган хаалт Ф300	2023	10	ш	2,500,000.00	25,000,000.00
29	Цутгамал лотки	2023	4100	м	200,000.00	820,000,000.00
30	Голчтой шугам	2023	4186	м	339,403.00	1,420,740,958.00
31	Цайрдсан ган хоолой	2023	21	ш	2,500,000.00	52,500,000.00
32	Худаг	2023	1	ком	15,000,000.00	15,000,000.00
Нийт дүн			12836			4,593,739,727.00
			(арван хоёр мянга найман зуун гучин зургаа)			(дөрвөн тэрбум таван зуун ерэн гурван сая долоон зуун гучин мянга есөн төгрөг долоон зуун хорин долоо)

